

БАТЛАВ
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

А.АРИУНЗАЯА

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР
+993 95 75523 ШТТ 6740 9131817

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧИЙГ ТОРГОХ
ШИЙТГЭЛ, АЛДАНГИАС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтооолоор коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд эрчим хүчээр хангах үйл ажиллагаа, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа, улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, шүүх, оршуулгын үйл ажиллагаа явуулдаг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдээс бусад байгууллагуудын үйл ажиллагаа зогсоод байна. Үүний улмаас зарим аж ахуйн нэгж байгууллагын болон иргэний бизнесийн үйл ажиллагаа доголдож, орлого буурч, нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлж чадахгүй байх нөхцөл үүсэж байна.

Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь нийгмийн даатгалын шимтгэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж, мөн зүйлийн тайлбар хэсэгт “-Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алданги тооцох ба уг алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэж тус тус заасан.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой үйл ажиллагаагаа нь зогсож, орлогогүй болсон аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн Зөрчлийн тухай хуульд

засны дагуу торгох шийтгэл, алданги төлөх нь санхүүгийн дарамтыг улам нэмэгдүүлэхээр байна.

Иймд аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг санхүүгийн дарамтаас хамгаалах зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд тайлагнасан боловч шимтгэлээ төлөөгүй, эсхүл дутуу төлсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуульд заасан торгох шийтгэл, алдангиас тодорхой хугацаанд чөлөөлөх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж байна.

2.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг бие даасан хууль хэлбэрээр боловсруулах бөгөөд Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг үнэн, зөв мэдүүлж, нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн боловч нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй, дутуу төлсөн, аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт болон мөн зүйлийн тайлбарт заасан торгох шийтгэл, алдангиас чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Ингэхдээ хуулийн үйлчлэлд хамаарах хугацааг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл байхаар тусгана.

3.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хуулиар 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, алдангиас чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээний хүрээнд 6.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага 13.9 тэрбум төгрөгийн торгох шийтгэл, алдангиас чөлөөлөгдсөн.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа үнэн, зөв мэдүүлэн ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний бизнесийн болон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд санхүүгийн дарамт нэмж учруулахгүй байх нөхцөл бүрдэнэ. Хуулийн үйлчлэлд 10.0 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллага 30.0 тэрбум төгрөгийн торгох шийтгэл, алдангиас чөлөөлөгдөх урьдчилсан тооцоо гарч байна.

4.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---